

ЖОНАНБЫН ЁСНЫ ОНЦЛОГИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

С.Янжинсүрэн (Ph.D)
Ц.Гантөмөр (Докторант)
Философи, шашин судлалын тэнхим.
ШУС. МУИС

Түлхүүр үг: Жонан, Жонанба, Жонанбын ёс, тав дахь тогтсон таалал, Гүнбан Түгжэ Зундуй, Жансэм Жалва-Ешэй, Хайзүн Ёндон-Жамц, Найруулгын зургаан гишүүнт.

Товч утга: Тус өгүүлэлд Төвдөд хөгжсөн буддизм дэх нэгэн ээдрээтэй сэдэв Жонанбын ёс, түүний гарал үүсэл, үзэл санааг товч тодорхойлохыг оролдов. Өнөө хэр энэ ёс, энэ үзэл онолыг төвд дэх буддын шашны бие даасан ёс, бие даасан урсгал биш гэж үзэх нь элбэг юм. Гэтэл энэ ёсны ном зохиол олон бөгөөд түүний сургалт, судалгаа тасралтгүй үргэлжиж байна. Төвдөд дэлгэрсэн Бурханы шашинд 5 дахь ёс, тав дахь тогтсон таалал болж Цогт Ялеуусан Жонанбын ёс, дамжлага XII дугаар зууны үед Юму Мижид Дорж (1016-1100) үүсгэсэн бөгөөд судар тарнийн ёс хосолсон төв үзлийн “Бусдаар хоосон” гэх гүн ухааны үзлийг төвдийн сэтгэгч Долбуба Шэйрав-Жалцан (1292-1361) дэлгэрүүлсэн нь энэ ёсны төв үзлийн ёс, хоосон чанарын онол нь болсон байна.

Төвдийн дуун хөрвүүлэгч Гаави-Дорж, Дави-Одсэр, Шэйрав-Дагба нар 1027 онд энэтхэгээс Дүйнхор бурханы дандар болон тайлбар, Бодь сэтгэлийн тайлбар номуудыг төвд хэлэнд хөрвүүлсэн нь энэ ёс үүсэх эхлэл болсон байна.

Жонанбын ёсны сүм хийд, лам хуврага Төвд, Энэтхэг, Монголд үйл ажиллагаа явуулж байгаа болно.

* * * * *

Жонанбын ёсны түүхийн онцлог

Бурхан багшийн сургаалийг Төвдийн орчуулагч багш нар Энэтхэг хэлнээс өөрийн хэл рүү орчуулж тэдгээр орчуулагч багш нар болон орчуулгын бүтээлүүдээр дамжин Буддын философи Төвдөд дэлгэрсэн ч он цаг, газар нутаг, түгээн дэлгэрүүлэгч болон хөгжүүлэгчдийн эрхээр олон урсгал болж салбарлан хөгжсөн юм. Тэдгээрийг дурдвал Нинма (ཉིང་མ), Сажа (ས་ཟླ), Гаржүд (གཤམ་བརྒྱུད), Гэлүг (དགེ་ལྷན་པ་), Жонан (རྗོ་ནང) юм.

1. Нинма

Төвдөд дэлгэрсэн урсгалаас хамгийн анхных нь Нинма юм. Нинма нь хуучин гэсэн үг ба Төвдөд анх дэлгэрсэн тарнийн ёс мөн учир тэгж нэрийдсэн байна. Энэ урсгал нь Энэтхэгийн Ловон Бадамжунайгаас дамжин Төвдийн Биразана (བིར་ཙ་ན) тэргүүтэй шавь нараар дамжин дэлгэрсэн. Одоо энэ урсгалын

гол лам нь Дэлгочэнзэ (ᠳᠡᠯᠭᠣᠴᠡᠨᠵᠡ) хувилгаан юм.

2. Гаржүд

Гаржүд гэж Бурхан багшийн ном сургаал буюу зарлигийг дамжуулагч гэсэн утгатай үг болно. Төвөдийн сэтгэгч Марав лам Чойжилодой (ᠮᠠᠷᠠᠪ ᠯᠠᠮ ᠴᠣᠢᠵᠢᠯᠣᠳᠣᠢ 1012-1097) Энэтхэгт 3 удаа, Непалд 4 удаа очихдоо Нароба (ᠨᠠᠷᠣᠪᠠ) тэргүүтэн 108 ламаас Сандуй, Дэмчиг тэргүүтэй ямандаг бурхадын авшигийг авсанаар энэ ёс үүсэх эхлэл тавигджээ. Марав лам Чойжилодойгоос шавь Мила богд (ᠮᠢᠯᠠ ᠪᠣᠭᠳᠤ 1042-1123) нь залган авч түүнээс Дагбу ринбучид (ᠳᠠᠭᠪᠤ ᠷᠢᠨᠪᠤᠴᠢᠳ) дамжин уламжлагджээ. Гаржүдийн ёс нь дотроо их 4, бага 8 урсгал болж салбарлан хөгжсөн бөгөөд одоо энэ урсгалын тэргүүн нь Гармаба (ᠭᠠᠷᠮᠠᠪᠠ) лам юм. Гармаба нь Монголын эзэнт гүрний их хаадын багшаар 1255 онд залагдаж байсан тул монголчууд Гарма багш гэдэг нэрийг өгсөн түүхтэй бөгөөд монголчуудын бурханы шашинтай холбогдсон түүх энэ ёстой салшгүй холбоотой. Гармавын ёсны лам Мөнх хааны багш байсан болно.

3. Сажа

XI зууны үед төвөд сэтгэгчид санскрит хэлнээс төвөд хэлнээ Бурханы шашны ном зохиолыг орчуулж эхэлсэн нь Сажа ёс үүсэх эхлэлийг тавьжээ. Төвөдийн их хэлмэрч Хон Гончигжалбу (ᠬᠣᠨ ᠭᠣᠨᠴᠢᠭᠢᠵᠠᠯᠪᠤ) хөрвүүлгийн ажлыг эхлүүлсэн ба хожим нь Сажа буюу цайвар шороот гэдэг нэртэй газар хүрээ хийдээ байгуулж, улмаар тэр хийдүүдийг тухайн газрын нэрээр нэрлэх болсон ба басхүү энэ ёсны ч нэр болж тогтсон юм. Сажийн ёсны 5 гол багшийг эл ёсны түүхэнд чухалчлан авч үздэг бөгөөд тэдгээр нь Хон Гончигжалбугийн ач хөвгүүд болох **Сачэн Гүнгаанямбуу** (ᠰᠠᠴᠡᠨ ᠭᠦᠨᠭᠠᠨᠶᠠᠮᠪᠤ 1092-1158), **Содномзэмо** (ᠰᠣᠳᠨᠣᠮᠵᠡᠮᠣ 1142-1182), **Дагбажалцан** (ᠳᠠᠭᠪᠠᠵᠠᠯᠴᠠᠨ 1147-1216), **Саж бандид Гүнгаажалцан** (ᠰᠠᠵᠢ ᠪᠠᠨᠳᠢᠳ ᠭᠦᠨᠭᠠᠵᠠᠯᠴᠠᠨ 1182-1251), **Догончойжал Пагба** (ᠳᠣᠭᠣᠨᠴᠣᠢᠵᠠᠯ ᠫᠠᠭᠪᠠ) нар юм.

Эдгээр 5 сэтгэгч бүгд Монголын эзэнт гүрний их хаадтай харилцаатай байж, шашин соёлын асуудлуудаар санал солилцдог, Бурханы шашны үзэл онолыг заадаг номын барилдлагатай байсан нь түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ.

Сажийн ёсны дамжлага нь бусад ёсны дамжлагаас өөрөөр уламжлагддаг онцлогтой. Энэ ёс нь дэлхийн төрт ёсны түүхэнд байдаг хаан ширээ уламжилдаг ёс адил хүүгээс хүүд уламжлагддаг бөгөөд одоо Сажа Тидзэн хувилгаан нь (ᠰᠠᠴᠡᠨ ᠭᠦᠨᠭᠠᠨᠶᠠᠮᠪᠤ) Сачэн Гүнгаанямбуугаас энэ ёсны гол ламын орыг залгамжилсан 42 дахь ширээт лам бөгөөд гэнэн сахил сахидаг гэргийтэн хүний ёсоор явдаг урсгалын тэргүүлэгч нь юм.

Энэ ёс нь Гүюг хааны үед Монголд нэвтэрсэн бөгөөд Саж бандид Гүнгаажалцан улсын багшаар залагдаж түүний зохиосон “Эрдэнийн сан Субашид” сонгодог зохиолыг өнөө хэр нь монголчууд уншиж судалдаг. Зохиол ёс зүйн үлгэр болдогоороо түүхэн ая холбогдолтой бүтээл болно. Харин Догон Пагба лам нь Монголын дөрвөлжин үсгийн зохиогч бөгөөд энэ бичиг хэдийгээр удаан хэрэглэгдээгүй ч төрийн бичиг болж байсан түүхтэй.

Тэрээр Гүюг хааны заллагаар Монгол нутагт ирсэн боловч тэр үед Гүюг хаан таалал барьсан тул дүү Годун ноён Ланжоуд уулзсан түүхтэй. Ер нь Өгөөдэй хаанаас Тогоонтөмөр хаан хүртэл Сажан болон Гармабын лам нар улсын багш болоод хааны багш болж байжээ.

4. Гэлүг

Богд Зонхав (ᠪᠣᠭᠳᠤ ᠵᠣᠨᠬᠠᠪ 1357-1419) бээр үзэл онолын олон байр суурийг цэгцэлж сургаал номлолоо гаргаж ирсэн нь шарын шашин болж хөгжжээ. Богд Зонхав гаднаа сахил санаваар, дэг жаягийг чандлан сахих, дотроо нууц тарнийн явдлыг эрхшээдэг нэгэн байсан тул судар хийгээд тарнийн сургаалыг хослуулсан бурханы шашны шинэ урсгалыг үүсгэсэн нь энэ Гэлүг буюу шарын шашин болж хөгжсөн юм.

Шарын шашин нь ёс журам, үзэл онолоороо бусад урсгалаас дараахь зүйлсээр ялгарна. Үүнд,

Нэгдүгээрт: Нинма, Сажан, Гаржүд, Жонан ёсны лам нар улаан өнгийн бадида малгай өмсдөг бол Гэлүгийн ёсны лам нар ганцаараа шар өнгийн малгай өмсдөг

Хоёрдугаарт: Хоосон чанарыг үзэх үзлээрээ ялгаатай

Гуравдугаарт: Сахил санваарын ёсоороо ялгаатай

Буюу энэ ёс бусад ёсноос хэлбэрээрээ болон агуулгаараа ялгаатай юм.

5. Жонанба

Төвөдөд дэлгэрсэн Бурханы шашинд 5 дахь ёс, тав дахь тогтсон таалал болж Цогт Ялгуусан Жонанбын дамжлагыг XII дугаар зууны үед Юму Мижид Дорж (ᠶᠤᠮᠤᠮᠢᠵᠢᠳᠣᠷᠵᠢ 1016-1100) үүсгэжээ. Судар тарнийн ёс хосолсон төв үзлийн “Бусдаар хоосон” ᠪᠤᠰᠳᠠᠭᠤ ᠬᠣᠭᠤᠰᠣᠨ гэх гүн ухааны онолыг Долбуба Шэйрав-Жалцан (ᠳᠣᠯᠪᠤᠪᠠ ᠰᠡᠢᠷᠠᠪ ᠵᠠᠯᠴᠠᠨ 1292-1361) дэлгэрүүлсэн нь энэ ёсны төв үзлийн ёс, хоосон чанарын онол нь болсон байна.

Судар тарнийн ёсыг хослуулсан энэ дамжлагыг дуун хөрвүүлэгч Гаави-Дорж (ᠭᠠᠠᠪᠢ ᠳᠣᠷᠵᠢ), Дави-Одсэр (ᠳᠠᠪᠢ ᠣᠳᠰᠡᠷ), Шэйрав-Дагба (ᠰᠡᠢᠷᠠᠪ ᠳᠠᠭᠪᠠ) нар 1027 онд Дүйнхор бурханы дандар болон тайлбар, Бодь сэтгэлийн тайлбар номуудыг Төвөд хэлэнд хөрвүүлсэн нь энэ ёс үүсэх эхлэл болсон байна. Өмнө нь энэ дамжлагыг Цагийн хүрдний бясалгаач, Жордүмба (ᠵᠣᠷᠳᠦᠮᠪᠠ) Зургаан найруулгатай хэмээн нэрлэдэг байжээ.

Бясалгал, төвлөрлийн арга зүйг төгс эзэмшсэн Юму Мижод-Доржоос (ᠶᠤᠮᠤᠮᠢᠵᠢᠳᠣᠷᠵᠢ) Гүнбан Түгжэ Зундуй (ᠭᠦᠨᠪᠠᠨ ᠲᠦᠭᠵᠡ ᠵᠤᠨᠳᠦᠢ 1243-1313) уламжилж Үй ᠦᠶᠢ Зангийн ᠵᠠᠨᠭᠢᠨ “Жомонанва” ᠵᠣᠮᠣᠨᠠᠨᠠᠪᠠ нэртэй газарт энэ ёсны анхны хийдийг барьсан учир анхны тэр сүм хийдийг байгуулсан тус газрын нэр нь энэ ёсны нэр болж нийтэд тогтсон түүхтэй.

Гүнбан Түгжэ Зундуй нь Дүйнхор бурханы **“Найруулгын зургаан гишүүнт”** гэж томъёолдог бясалгалын арга зүйг өөрийн шавь Жансэм Жалва-Ешэйд (ᠵᠠᠨᠰᠡᠮ ᠵᠠᠯᠪᠠ ᠡᠰᠡᠢᠳᠡ 1257-1320) өгсөн байна. Тэр бээр Жонанбын залгамжлагч Хайзүн Ёндон-Жамц (ᠬᠠᠶᠢᠵᠦᠨ ᠶᠥᠨᠳᠣᠨ ᠵᠠᠮᠴᠢ 1260-1328)-д дамжуулжээ.

Энд нэрлэж байгаа **Гүнбан Түгжэ Зундуй, Жансэм Жалва-Ешэй болон Хайзүн Ёндон-Жамц** гурвыг Жонан ёсны анхны 3 багш хэмээн тус ёсныхон ихэд хүндэтгэнэ. Анхдагч бүхэн хүндтэй байдаг нь аль ч соёлд байдаг түгээмэл үзэгдэл болно.

Төвөдийн сэтгэгч, бясалгалч Долбуба Шэйрав-Жалцан нь Жомонанва гэдэг газар очиж Хайзүн Ёндон-Жамцаар удирдуулан Дүйнхор бурханы “Найруулгын зургаан гишүүнт” бясалгалын арга зүйд суралцаж залгамжилсан түүхтэй.

Жонанбын ёсоор бол Төв үзлийн онолын үндсийг айлдсан Майдарын гэгээн **Хэй-вэцжэ-цэжэ-ва**, Асанга **Асанга** **Асанга** **Асанга** хэлмэрч Гаавидорж нарын таслалгүй дамжуулсан судар хийгээд тарнийн ном, тэдгээрийн арга зүйг Долбуба Шэйрав-Жалцан бүрэн эзэмшиж, шавь нартаа дэлгэрүүлсэн нь хожим энэ ёс тасралтгүй уламжлагдах үндэс болсон юм. Олон ном сударт түүнийг “Бүхнийг мэдэгч Долбуба Шэйрав-Жалцан” гэж нэрлэдэг бөгөөд тэрээр жонанбын ёсыг машид дэлгэрүүлсэн гэж гардаг.

Долбуба Шэйрав-Жалцан нь Дүйнхор бурханы бясалгалын арга зүйг дэлгэрүүлээд зогсохгүй жонанбын ёсны хоосон чанарын онолын “Бусдаар хоосон” **lgshan stong** гэх үзлийг үндэслэн дэлгэрүүлсэн учир түүнийг тус ёсны төв үзлийг үндэслэгчид зүй ёсоор тооцно.

Буддын гүн ухааны тогтсон таалал бүгд өөр, өөрийнхөөрөө төв үзлийг барьж, хоосон чанарыг оносон хэмээн үздэг тул түүний бусдаар хоосон хэмээн үздэг энэ онол жонан ёсыг дэлгэрэхэд хүчтэй нөлөө үзүүлсэн, онолын суурь нь мөн гэж үздэг. “Бусдаар хоосон” хэмээх жонан ёсны гүн ухааны үзлийг Бурхан багшийн айлдсан 3 дахь номын хүрд **Асанга**, мөн Нагаржунайн зохиосон “Хоосон чанарын магтаал” (**Хэй-вэцжэ-цэжэ-ва**), Майдарын гэгээн (**Хэй-вэцжэ-цэжэ-ва**), Хутагт Асанга (**Асанга**) нарын бүтээлд тулгуурлан хөгжүүлсэн байна.

Долбуба Шэйрав-Жалцангийн дараа Жонанбын ёсыг Жэвзүн Дараната Гунгаа-Нинбуу (**Хэй-вэцжэ-цэжэ-ва** 1575-1635) залгаж, бясалгал бүтээлийн олон хийд орныг байгуулсан нь Жонан ёс хүчтэй дэлгэрэх бас нэг шалтгаан болсон байна. Жонанбын урсгалд хамгийн алдартай нь Жонан Дарнатын гэгээн болно.

Жонанбын ёсны үзэл сургаал, түүний онцлог

Бурханы шашинд дээр дурдсан урсгал, сургаалууд байгаа ч Жонанбын ёсны үзэл нь Дүйнхорын ёсны зургаан шатлалт найруулгын бясалгал болон түүний өөрийнх нь ёсны хоосон чанарыг онох үзлээрээ буддын шашны бусад урсгалаас онц ялгаатай.

Буддын философийн хоосон чанарын онолыг Рандон (**Асанга**) буюу өөрөө хоосон, Шандон (**Асанга**) буюу бусдаар хоосон гэсэн хоорондоо ялгаатай арга зүйгээр тайлбарладаг.

Рандон буюу өөрөөр хоосон чанар гэж юмс үзэгдэл анхнаасаа өөрөөсөө бүтээгүй бөгөөд өөрөөсөө бүтсэн зүйл нэг ч байхгүй гэх ба харин учир шалтгааны үүднээс харилцан хамаарч нэрийтгэл төдий оршдог гэж үздэг бол Шандон буюу

бусдаар хоосон чанар гэдэг нь бүх зүйл хоосон чанартай гэдгийг үгүйсгэдэг боловч бурханы мөн чанар буюу “гэгээн гэрэл” (འོད་གསལ) нь анхнаасаа байсан, мөнх зүйл, харин түүнээс бусад юмс үзэгдэл бүгд хоосон чанартай гэж үзнэ. Үүгээрээ гэлүгбийн ёсноос ялгардаг юм.

Жонанбын ёсны бас нэг онцлог нь Цогт цагийн хүрдний (དཔལ་དུས་ཀྱི་འཁོར་ལོ) номлолын хувьд Наробагаас уламжилсан Найрлагын зургаан гишүүнтийн арга зүйг таслалгүй хөгжүүлсэн явдал болно.

Бурхан багш Цогт цагийн хүрдний номлолыг анх Амарабатид айлджээ¹. Түүний шавь Шамбалын орны хаан Шучандра буюу Даваасамбуу (ཤུམ་ཇཱ་ལའི་རྒྱལ་བོ་རྒྱལ་བཟང་པོ) бээр энэ цагийн хүрдний номлолын дамжлагыг авч улмаар Шамбалын оронд Цогт цагийн хүрдний номлолыг хэдэн зуун жилийн турш дэлгэрүүлсэн бөгөөд Шамбалын хаан Жалбалдагва (འཇམ་དཔལ་གྲགས་པ) болон түүний хүү Пүндарига нар хялбаршуулан системчилсэн юм.

Цагийн хүрдний номлол нь тантрын ёсны (ཐུགས་ལུགས) үндсэн арга барилуудыг хэвээр нь хадгалж үлдсэн ба 84 шидтэний нэг Нарова (ལྷ་རྩེ) арга зүйг нь баяжуулж, бас зарим талаар хялбаршуулсан гэдэг байна.

Цагийн хүрдний номлол нь Тантрын ёс болон Очирт Хөлгөний (རྗེ་ཐེག་པ) ёсны бясалгалын дасгалуудыг агуулсан байдаг. Зарим буддын шашны онолчид Цагийн хүрдний номлолыг Очирт хөлгөнд орох үндсэн арга гэж үзнэ. Цагийн хүрдний номлолыг санскритаар Калачакра гэх ба Кала (རྒྱལ) буюу цаг хугацаа, Чакра (འཁོར་ལོ) буюу хүрд гэсэн утгатай бөгөөд хүний биеийн энергийг ашиглан бясалгал хийснээр гэгээрэлд хүрэх арга замыг заадаг гэж үзнэ. Цагийн хүрдний ёсыг 5 хэсэгт хуваадаг.

Эхний хэсгийг гадаад цагийн хүрдэн гэх бөгөөд энд дэлхий ертөнцийн тогтоц бүтцээс авахуулаад хүний төрөх, үхэх хүртлэх амьд организмын хөгжлийн бүх үйл явцыг тайлбарлана.

Удаахь хэсгийг дотоод цагийн хүрдэн гэх бөгөөд энд хүний үүсэл бүрдэлээс төрөх хүртэлх үеийг авч үзэж, хүний 4 төрлийн оюуны байдлыг ялгаж гаргана. Үүнд: сэрүүн байх, зүүдлэх, гүн нойрсох болон дусал хураах үеийн оюун санааны төлөв орно.

Сүүлийн гурвыг бусад болон сонголттой цагийн хүрдэн гэх бөгөөд гурав дахь хэсэг нь бясалгалын дасгал хийхэд бэлдэх шат юм.

Дөрөв дэх хэсэгт Зургаан үет найруулгын бясалгал байна. Зургаан үет найруулгын бясалгалыг Энэтхэгийн их бүтээлч 84 шидтэний нэг Нарова бээр үндэслэн төгс хэлбэрт оруулсан бөгөөд үүнийг шат дамжлагаар нь үзвэл:

1. Дүммо (གཏུམ་མོ) буюу Дотоод энергийн бясалгал
2. Жүлү (ཇུ་ལུ) буюу Хоосон биеийн бясалгал
3. Одсал (འོད་གསལ) буюу Гэгээн гэрлийн бясалгал

¹Цогт цагийн хүрдний үндэст энэ тухай тодорхой бичжээ.

4. Милам (མི་ལམ) буюу Зүүдний бясалгал
5. Бард (བར་དོ) буюу Зуурдын үеийн бясалгал
6. Пова (འཕོ་བ) буюу Бурханы мөн чанарт шилжих бясалгал орно.

Эхний 3 шатыг төгсгөлийн зэрэг гэх үзэх бөгөөд бясалгалын үндсэн арга барилыг эзэмшсэн гэж үздэг. Дээрх 6 үет найруулгын бясалгалыг хийхийн өмнө Наропагийн зохиосон 6 үет дасгал хөдөлгөөнийг хийдэг байна.

Бясалгалын энэ арга зүйг I, II, VII, VIII, XIV Далай лам нар судалснаас Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Дүйнхорийн ванг Дэлхий нийтэд 34 удаа тавиад байгаагаас Монголд 1995 онд нэг удаа номложээ.

Ялангуяа Жонон Дарнатын үзэл онол нь Гэлүгбийн ёстой нягт холбоотой учраас XIV Далай лам Жононбын ёсыг ихээр хүндлэн ном айлдах болгондоо дурддаг.

Жононбын урсгал Монгол оронтой хэрхэн холбогдсон тухай

Халхын Өндөр гэгээн Занабазарыг (1635-1723) 1639 онд Банчэн богд Жононбын ёсны тэргүүн лам Жонон Жэвзүн Дарнатын хойд дүрийн хувилгаанаар тодруулж байв. Энэ цагаас эхлээд Халхын богдууд Гэлүгва ба Жононбын ёсны эзэд байв. Төвдөөс тодорсон Богдууд багадаа Монголд залагдан ирдэг байсан ч Монголд Шарын шашин хүчтэй дэлгэрсэн учир Жононбын ёсны тэргүүн боловч энэ ёсыг монголд ил гаргах боломж байгаагүй юм.

Учир нь анхдугаар Богд Жэвзүндамба хутагтыг Жононбын эзнээр өргөмжилсөн ч тэр үеийн улс төрийн нөхцөл байдал болон Жононбын хоосон чанарыг үзэх үзлээс шалтгаалан энэ ёсыг “дорд” үзэх, түүнээс болж сүм хийдийг нь хаах, ном зохиолыг нь судлахыг хориглох, нэрийг нь солих, лам нарыг нь тараасан зэрэг сөрөг нөхцөлтэй тулгарч байсан нь түүхэн үнэн болно.

Нөгөө талаас Жонон Дарнат нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн лам байсан ба бусад урсгалуудын тэргүүн лам нарын шахалт, өөр өөрийн онолыг зөвтгөх үзэл, шашинд эзлэх байр суурь нь адилгүй байсантай холбоотой ийнхүү дарагдаж хоцорсон юм.

Энэ байдал нь далд хэлбэрээр хэдэн зууныг дамжин үргэлжилж Төвөд оронд 1939 онд шашин болон шашны урсгалуудыг засгийн газраас дахин батлахад Жононбын ёсыг бие даасан урсгалын тоонд оруулаагүй бөгөөд Сажа ёсны нэгэн шинэчилсэн урсгал гэж заасан байна.

Сажа ёс нь хоосон чанарыг онох үзэл болон гол үзлээрээ Жононбын ёсноос ялгаатай. Сажа ёсны гол онол нь ЗОГЧЭН (རྩོགས་ཚུན) буюу төгсгөлийн зэргэмж болно.

Төвдүүд 1959 оноос эхлэн Энэтхэгт дүрвэн гарснаас хойш Жононбын ёсны лам нар өөрийн ёсны онол, сургаалыг Засгийн газраараа шийдүүлэхээр удаа дараа арга хэмжээ авсан юм. Дээрхийн гэгээн XIV Далай лам ч олонтой энэ зүйлийн талаар зөвшөөж байсан боловч төдийлөн үр дүнд хүрэлгүй өнөөдрийг хүртэл асууулт хэвээрээ үлдсэн юм.

Жонанбын урсгалын өнөөгийн байдал

Түүхэн цаг үеийг ийнхүү давсан Жонанбын ёс нь Жонан Дарнат ламын дараа цагийн эрхээр Төвдийн Үй (དབུས), Зан (གཙང), Лхасад (ལྷ་ས) төдийлөн хүчтэй дэлгэрээгүй ч Амдо (མ་མདོ) нутгийн Нгава (ར་བ), Замтан (འཛམ་གཙང), Жалрон (རྒྱལ་རྩོང), Голог (མགོ་ལོག) нэртэй аймгуудаар 10.000 гаруй лам хуврагатай 60 гаруй хийд, Энэтхэгт 2, Балбад 2, Монголд 2 хийд байна.

Мөн Америк, Орос , Бельгид номын төвүүд үйл ажиллагаа явуулж байна.

Монголд дэлгэрч байгаа жонанбын ёс нь бусдаасаа өвөрмөц юм. Үе үеийн богдуудын хэрэгжүүлж чадаагүй үйлийг IX богд Жэвзүндамба хутагт Жамбалнамдолчойжийжалцангийн (ལལ་ལ་རྩེ་བཙུན་དམ་པ་འཇམ་དཔལ་རྣམ་པོའ་ཚེས་ཀྱི་རྒྱལ་མཚན) удирдсан дагуу Төвөдийн Жонанбын лам, шанзодва Акугунгаагийн (མ་ལུ་ཀུན་དགའ) санаачлагаар 2005 оноос эхлэн Монгол улсаас 32 хүүхдийг БНЭУ-д 5 жилийн хугацаатайгаар Жонанбын ёсны зан үйл хурал уншлагад суралцуулж байна.

Тэдгээрийн зарим лам нар эх орондоо эргэн ирж "Жонан Дагдан Миндоллин" \Жонан ёсны хувиршгүй гэтэлгэгч\ хийдийг 2014 оны 11 сарын 26 ны өдөр байгуулж IX Богд Жэвзүндамба хутагт сэрүүн байхдаа нэрийг нь хайрласан түүхтэй.

Энэ нь Монгол дахь Жонанбын ёсны анхны бөгөөд төв хийд нь болж 18 ламын бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутмын хурлаа тогтмол хурж, бурхны шашны ном сургаал, Жонанбын ёсны түүх судруудыг хөрвүүлэн олон нийтэд хүргэх, таниулах, уламжлалт зан үйлийг хөгжүүлэх, соёлыг өвлүүлэхэд хувь нэмэр оруулах, Жонанбын ёсыг даган баригч лам нарын боловсролыг дээшлүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг тууштай явуулж байна.

Бурханы шашины онолын асуудлууд Жонанбын, Гэлүгвийн, Сажавын, Гаржүдвийн ёс гэж олон салбарлан хөгжсөн ч тэдний зорилго нь нэг тул хоорондоо харшлахгүй гэж үзэж байгаа болно. Үүнийг Богд Зонхова бээр "Бодь мөрийн зэрэг"-тээ шашин бүгд хоорондоо харшлахгүй хэмээн айлдсанаар тайлбарлаж болно гэж үзнэ .

НОМ ЗҮЙ

1. Жонанбын ном гарсан түүх, Жонан Дарнат.
2. Дотоод ухааны гуу сан, мунхагийг арилгагч зул, Олон мэргэдийн товчоон, 1, 2 дугаар дэвтэр.
3. Жонанбын их ерөөл, УБ., 2017. \Монгол дахь Жононбын ёсны төв Дагдан миндоллин хийд\
4. Лодойдонёджи. Дүйнхорын ёсны ном гарсан түүх, Индранилын найлзуур судар.
5. Туган Чойжиняма. Тогтсон таалал.\судар\
6. Gen Lamrimpa and B.Allen Wallace , An Explanation of the Kalachakra Six-session Guru yoga, 1999.
7. John Newman, The wheel of Time, Shanbala, 1991.
8. Stearns Cyrus, The Buddha from Dolpa, 2010.
9. Mullin Gruschke. The Jonanpa Order.2009.

ABSTRACT

In this article, we tried to consider about unique issues of “Jonang pa” tradition of Buddhism, which was developed in Tibet, its’origin and worldview in brief.

Today, some people deeming the “Jonang pa” is not a substantive tradition of Tibetan Buddhism. But the Jonang pa tradition has rich stock of sutras and books and has a ceaseless continuation of its teaching and study.

In the XII century the Jonang pa tradition founded in Tibet by Yu mo Mi bskyod rdo rje (1016-1100). Dolpopa Shes rab grags pa (1292-1361) formulated the treatise of Others emptiness (gzhang stong) and the treatise become Jonang pas’ main character.

In 1027, Tibetan famous translators dKa ba’i rDo rje, zla ba’i od zer, Shes rab grags pa borrowed main sastras of “Dui khor” from India. It was influenced to develop Jonang pa tradition in Tibet deeply.

Now, monasteries and lamas of Jonang pa tradition are developing its own treatise in Tibet, in India and in Mongolia.